



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/180

Мандалговь

Монголын Шинэ цирк төвд дэмжлэг
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.10, 16.1.12, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 7 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. МҮОНРТ, Монголын Шинэ цирк төв хамтран бүтээж буй Дэлгэрхангай сумын уугуул Монгол Улсын Гавьяат жүжигчин, Алдарт алиалагч Дамбын Батсүх агсны амьдрал, уран бүтээлийн баримтат киноны ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 2,500,000 (Хоёр сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100441